

2006 онд БНХАУ өсөлтөө хянах ба Зүүн Азийн эдийн засгийн өсөлт тогтвортой байна

Хонг Конг, БНХАУ (2006.04.06) —2006 онд Зүүн Азийн эдийн засаг 7.7%-ийн тогтвортой өсөлттэй байх бөгөөд 2007 онд 0.5 орчим хувиар буурч 7.1% болох төлөвтэй байна хэмээн өнөөдөр Азийн Хөгжлийн Банк (АХБ)-наас гаргасан томоохон тайланд дурьджээ. Тус бүс нутгийн эдийн засаг 2005 онд 7.7% -иар өсчээ.

2006, 2007 онд бүс нутгийн инфляци бага зэрэг өсч 2.4% болон 2.7%-д тус тус хүрэх бөгөөд энэ нь Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ) болон Хонг Конг-д цахилгаан, хий, ус болон газрын тосны бүтээгдэхүүний зохицуулалттай үнэ өсөх хандлагатай байгаагаас шалтгаалж байгаа аж.

“БНХАУ эдийн засгийн өсөлтөө зориудаар удаашруулах арга хэмжээ авах тухай шийдвэр гаргасан нь ирэх жилүүдэд Зүүн Азийн өсөлтөд хамгийн ихээр нөлөөлөх хүчин зүйл болно” хэмээн АХБ-ны ерөнхий эдийн засагч Ифзал Али АХБ-ны эдийн засгийн хамгийн чухал хэвлэл болох “Азийн хөгжлийн урьдчилсэн төлөв байдал” (АХУТБ) товхимолын 2006 оны дугаарыг танилцуулахдаа хэлсэн байна.

Тэрбээр “БНХАУ-ын эдийн засаг эрчимтэй өсөх нь дамжиггүй бөгөөд сүүлийн жилүүдэд маш эрчтэй хөгжиж ирсэн эдийн засагт сөргөөр нөлөөлсөн бүтцийн сул талуудыг шийдвэрлэх талаар Засгийн газраас авах арга хэмжээ нь дунд хугацаанд тус бүс нутгийн эдийн засаг тогтвортой өсөх боломжтой болгоно” гэжээ.

АХУТБ 2006 тайланд таамаглаж байгаагаар Азийн хөгжиж буй 43 орны эдийн засаг нийлбэр дүнгээрээ 2006 онд 7.2%, 2007 онд 7%-ийн өсөлттэй байх ажээ.

2005 онд БНХАУ-ын эдийн засаг хөрөнгө оруулалт, экспортын эрчтэй өсөлтөөс шалтгаалж 9.9% хувиар өсчээ. Гэвч хөрөнгө оруулалтын төвшин их өндөр байгаа нь зарим салбарын үйлдвэрлэлийн хэмжээг хэт өсгөж энэ нь сэтгэл зовиноож байна. 2006 онд тус улсын өсөлт эрчтэй хэвээр буюу 9.5%-тай байх бөгөөд 2007 онд 8.8% болж буурна. Цаашдаа эдийн засгийн өсөлт тогтворжих хандлагатай байх боловч үүний тулд иргэдийн хувийн хэрэглээг өсгөх замаар хэрэгцээг тэнцвэржүүлж хөрөнгө оруулалтын нөөц эх үүсвэрийг илүү оновчтой ашиглах шаардлагатай болно. Гэвч санхүүгийн тогтолцоо, хөдөлмөрийн зах зээл, улсын үйлдвэрийн газарт хийгдэх шинэчлэл бүрэн бус хийгдэх; орлогын эрх тэгш бус байдал улам даамжрах; байгаль орчны доройтол; олон улсын худалдааны зөрчлүүд зэрэг нь дээрхи таамаглалд сөргөөр нөлөөлж болзошгүй.

2005 онд Хонг Конгийн цэвэр экспорт өссөнөөс шалтгаалж эдийн засаг нь 7.3%-иар хурдацтай өссөн байна. Энэ өсөлтөд дотоодын хэрэгцээ нэмэгдсэн нь ч хувь нэмрээ оруулжээ. Үнийн төвшин 1.1%-иар өссөнөөс үзэхэд Азийн санхүүгийн хямралаас хойш үргэлжилсэн хэвээр байсан хэрэглээний үнийн бууралт зогсчээ. Хөдөлмөрийн зах зээлийн байдал хэдэн жилийн турш сул байснаа сайжирсан байна. Хонг Конгийн эдийн засаг ийнхүү өндөр өсөлттэй байсан нь БНХАУ-ын эрчтэй өсөлт болон дэлхийн эдийн засгийн ерөнхий таатай нөхцөлөөс шалтгаалжээ. Харин 2006 онд Хонг Конгийн эдийн засгийн өсөлт 5.5% болж буурах ба 2007 онд эх газрын Хятадын эдийн засгийн өсөлт удааширч Хонг Конгийн өөрийнх нь дотоодын зээлийн хүү өсөхийн хирээр энэ өсөлт 5% болж буурна.

2006 онд иргэдийн хувийн хэрэглээнд нааштай өөрчлөлт гарсанаас гадна бодит орлого өссөнөөс Өмнөд Солонгосын эдийн засгийн өсөлт 4%-д хүрсэн байна. Энэ жил томоохон, экспортын чиг хандлагатай пүүс компаниуд үл хөдлөх хөрөнгөд оруулах хөрөнгө оруулалтаа өсгөх хандлагатай байх бол зарим жижиг пүүс компаниуд хөрөнгө оруулалтаа өсгөхөд бэрхшээлтэй тулгарч байна. 2006 онд өсөлт 5.1%- болж хурдсах хандлагатай байгаа ба энэ нь хэрэглээ болон

хөрөнгө оруулалтын өсөлт, мөн дэлхийн электрон барааны борлуулалт сайжирсанаас шалтгаалж экспортын хэмжээ хоёр орон тоогоор өсөх төлөвтэйгээс үүдэлтэй. 2006 онд өсөлтөд эерэгээр нөлөөлөх мөчлөгт хүчин зүйлүүд багасна гэж тооцолбол эдийн засгийн өсөлт 2007 онд 4.9% болж буурах хандлагатай байна. Өсөлт дунд хугацаанд 4.5%–5%-тай байх хандлагатай байна.

2005 онд Монголын эдийн засаг эрүүл буюу 6.2%-ийн өсөлттэй байжээ. Зэс болон алтны дэлхийн зах зээлийн үнэ өндөр байсан нь уул уурхайн салбарын эрчтэй өсөлтөд нөлөөлжээ. Харин дэлхийн зах зээл дээрх оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний экспортод тогтоосон квот дуусгавар болсон нь боловсруулах салбарт хүнд цохилт болсон байна. Инфляцийн төвшин хоёр орон тоонд хүрчээ. 2006 онд ДНБ-ний өсөлт 6%-д хүрэх төлөвтэй байгаа бөгөөд 2004-2005 онд эрчтэй өсч байсан мал аж ахуйн салбар өсөлтийн хэвийн төвшинд ирэхийн хирээр эдийн засгийн өсөлт 2007 онд 5% болж буурах хандлагатай ба экспортын бараа бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл болон цаг агаарын нөхцөл байдалд эмзэг хэвээр байх болно. Хөрш орнуудын зах зээлтэй илүү уялдах нь хөгжилд дэмжлэг үзүүлнэ.

Хятадын Тайпейн эдийн засаг 2005 оны эцсээр дэлхийн зах зээл дээр электрон барааны борлуулалт өссөнөөс шалтгаалж 4.1%-иар өссөн байна. Энэ нь 2004 онтой харьцуулахад 2 хувиар бага байна. Эхний хагас жилд электрон барааны экспорт сул байснаас хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт татарч, харин хувийн хэрэглээ улам өсчээ. 2006 онд электрон барааны салбар борлуулт өсөх хандлагатай байгаа нь экспорт, хөрөнгө оруулалтад нааштай нөлөөлж өсөлт 4.4%-д хүрэх хандлагатай байна. Харин 2007 онд дэлхийн зах зээл дээрх электрон барааны хэрэгцээ бага зэрэг буурах хандлагатай байгаагаас гол төлөв шалтгаалж эдийн засгийн өсөлт 4% болж буурах магадлалтай.

Манилад төвтэй АХБ нь ядуу орнуудын эдийн засгийн тогтвортой өсөлт, нийгмийн хөгжил ба сайн засаглалыг дэмжих замаар Ази, Номхон далайн бүс нутагт ядуурлыг бууруулах зорилготой. 1966 онд байгуулагдсан энэхүү банк нь 64 гишүүнтэй бөгөөд тэдгээрийн 46 нь тус бүс нутагт оршдог улс орнууд юм. 2005 онд АХБ-наас нийт 5.8 тэрбум ам. долларын зээл болон 198.8 сая ам. долларын техникийн туслалцааг тус тус баталжээ.

Media Inquiries

Dave Kruger
Tel: +0918 939-9058
E-mail: dkruger@adb.org

Electronic versions of ADB news releases

ADB Online Media Center: media.adb.org
ADB web site: www.adb.org